



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн  
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 101,974,326 /нэг зуун нэг сая есөн зуун далан дөрвөн мянга гурван зуун хорин зургаа/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 92,500,241 /ерэн хоёр сая таван зуун мянга хоёр зуун дөчин нэг/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нийт 194,474,567 /нэг зуун ерэн дөрвөн сая дөрвөн зуун далан дөрвөн мянга таван зуун жаран долоо/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ХК /О.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

00-370